



Төрийн Тусгай Албан
Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг
Амжилтын төлөө өөрчлөлт

БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ
ХАРЬЦУУЛАЛТЫН ҮНИЙН САНАЛЫН
БАРИМТ БИЧИГ

БАРИМТ БИЧИГ/ГЭРЭЭНИЙ ДУГААР: ТТАХНЭ/202012001

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

Үнийн санал шалгаруулалтын нэр: “Бичиг хэргийн материал”

Үнийн санал шалгаруулалтын дугаар: ТТАХНЭ/202012001

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн тендерт оролцогч эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь Цахим тендер зохион байгуулах журмын дагуу хураамж 50,000 /тавин мянган/ төгрөгөөр www.tender.gov.mn –ээс оролцох эрхээ худалдан авна.

Үнийн саналыг ажлын 7 хоног **2020 оны 03-р сарын 03-ны өдрийн 13 цаг**-аас өмнө худалдан авах ажиллагааны цахим сайт болох www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан **2020 оны 03-р сарын 03-ны өдрийн 13 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцно**

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо,
Хуульчдын гудамж

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ- д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**7. Санал
болгосон үнэ,
түүнийг
үнэлэх**

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ байгуулах
эрх олгох тухай
мэдэгдэл**












- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.














Хоёр. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ








ОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ОӨЗ 1.1	<p>Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Санхүүгийн чадавхийг харуулах аудитаар баталгаажуулсан 2018, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлнэ.</p> <p>Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил: Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага, борлуулалтын үнийн дүнг нотлох 3-аас доошгүй гэрээ ирүүлнэ.</p> <p>Эрх бүхий оролцогч дараах нэмэлт материалыг тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тусгай зөвшөөрөл, дистрибьютерийн эрх; • Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт; • Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт; • Татварын цахим тайлангийн системээс авсан тодорхойлолт; • Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт; • Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тухай харилцагч банкны тодорхойлолт; • Бараа нийлүүлэлтийн хуваарь; • Худалдагч тал валютын ханшны өөрчлөлт, онцгой албан татвар нэмэгдэх болон гэрээний хугацаанд гарах аливаа асуудлыг бие даан хариуцах ба гэрээний үнэд нөлөөлөхгүй гэсэн албан бичгээр ирүүлэх • Гүйцэтгэгчээр шалгарсан оролцогч барааг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх, уг техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бууруулсан талаарх дүгнэлт, хэрэглэгчийн гомдол, шаардлага гарсан тохиолдолд гэрээг цуцалж, дараагийн шаардлага хангасан оролцогчтой гэрээ байгуулахыг зөвшөөрсөн тодорхойлолт; • Тендерийн баримт бичгийн гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ
ОӨЗ 2.1	<p>Үнийн санал хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: УБ хот, ЧД-ийн 4-р хороо, Хуульчдын гудамж</p> <p>Давхар болон өрөөний дугаар: ТТАХНЭ-ийн 6-р давхар 614 тоот</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр</p> <p>Цаг: 13 цаг 00 минут</p>
ОӨЗ 3.1	<p>Баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ажлын 5 хоногоос багагүй байна.</p>
ОӨЗ 3.2	<p>Оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх бичиг баримт нь Монгол хэл дээр байна.</p>
ОӨЗ 3.3	<p>Оролцогч Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бараа нийлүүлэхтэй холбогдуулан үнийг бусад валютаар санал болгон ирүүлэхийг “зөвшөөрөхгүй.”</p>
ОӨЗ 3.4	<p>Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: “шаардлагагүй”.</p>

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Д/д	Нэр төрөл	Техникийн тодорхойлолт болон стандарт	Барааны зураг
1	Тооны машин	18 орон бүхий casio, citizen-тэй дүйцэхүйц	
2	Нуруулдагч	297x210 мм –н Deli- тэй дүйцхүйц	
3	Цаас зүсэгч	297x420 мм хэмжээтэй байх	
4	Цаасны хутга	Механик цоожлогчтой байх	
5	Үдээсний машин	Нимгэн ном үдэх боломжтой эргэдэг байх	
6	ДВД уут	DVD, CD хийх боломжтой сайн чанарын байх	
7	Фото цаас	A4 хэмжээтэй 25 ширхэгтэй байх	
8	Хавтас нүхтэй	230x305 мм хэмжээтэй байх	
9	Слайд	210x297 мм A4 хэмжээтэй	
10	CD	700mb 52x sony-той дүүцэхүйц чанартай үйлдвэрийн гэмтэлгүй байх	
11	DVD	4.7gb 120 min цагаан өнгөтэй, чанартай үйлдвэрийн гэмтэлгүй байх	

12	Тодруулагч	Дотроо шингэнтэй Deli-тэй дүйцэхүйц	
13	Хайч	190 мм чанартай байх	
14	Наадаг бал	Запас сольдог байх smile 360-тай дүйцэхүйц	
15	Үдээс /бичгийн/	Төмөр материалаар хийгдсэн, стандартын deli-тэй дүүцэхүйц үдээс байх	
16	Штрих туузан	12 м тасалдалгүй гардаг сайн чанарын байх	
17	Хавтас /крона/	Иш нь их биендээ суусан сугархааргүй цайвар ногоон өнгөтэй байх	
18	Дугтуй А4 /цагаан/	А4 хэмжээтэй наадаг байх	
19	Дугтуй А5 /цагаан/	А5 хэмжээтэй наадаг байх	
20	Люминаторын цаас	А4 хэмжээтэй байх, стандартны байх	
21	Люминаторын машин	А3-А4 хүртэл хэмжээгээр бүрэх боломжтой, сайн чанарын байх	
22	Кассын лент /80мм/	80x60 хэмжээтэй зузаан цаастай, арилдаггүй байх	
23	Бичгийн тавиур	Төмөр болон хуванцар, 3-аас дээш тасалгаатай, стандартны байх	
24	Бар кодны цаас	50x30 хэмжээтэй сайн чанарын стандартны байх	
25	Кассын лент /57мм/	57x50 хэмжээтэй сайн чанарын стандартны арилдаггүй байх	
26	Маркер арилдаггүй	Нарийн гардаг, шилэн дээр бичих боломжтой, арилдаггүй байх	
27	Маркер	Сайн чанарын арилдаг маркер байх	
28	Стикер цаас	135 гр цагаан өнгөтэй А4 хэмжээтэй 50 ширхэгтэй байх	

29	Арьсан бүрэгч	Гялгар бүрэгч байх	
30	Баримт үдэгчийн гуурс	Хуванцар материалтай өргөн нь 4,8 мм урт нь 500 мм 100 ширхэгтэй байх	
31	Архивын хавтас	2 тал нь хоёулаа бор зузаан байх	
32	PVC хавтан	A3 хэмжээтэй цагаан өнгөтэй 2 талдаа наалддаг 50 ширхэгтэй байх	
33	Шохойтой цаас	200-250 гр 2 талдаа шохойтой 50 ширхэгтэй байх	
34	Соронзон наалт	A4 хэмжээтэй байх	
35	Фото цаас	210x297 мм 2 талаараа хэвлэх боломжтой, 1 тал нь гялгар нөгөө тал нь A4 цаас шиг 50 ширхэгтэй байх	

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг,

тамга: Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
 - 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²
 - 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**

Алдангийн нийт дүн: **[moo]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга,
тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан
тушаал)

(Тамга,
тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан
тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ___оны сарын___-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____нэр төрлийн барааг _____оны _____дугаар сарын___-наас _____оны _____дугаар сарын___-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай
мэдэгдэл; Бусад шаардлагатай баримт
бичиг⁴; Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий
нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн
хуваарь; Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]